

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Пунцагийн Зэвэг	Дугаар	L095
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Дэлгэрхаан
Төрсөн газар	Дэлгэрхаан сум	Төрсөн он	1923
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уугийн хурал	Сүм хийдийн дугаар	ХЭЖХ 014
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 15	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Уугийн хурал

-Дэлгэрхаан суманд ямар ямар хийд, хурлын газар байсан бэ?

Би өөрийнхөө сууж байсан хурлыг хэлнээ. Уугийн хуралд сууж байсан. Бугын шүтээн гэдэг нь хоёр ч хуралтай байсан юм. Лүндэгийн Нуваан гэдэг нэг нь дөрвөлжин дугантай хурал бариад хуучин хурал нь яахав сайхан гэр дугантай хуралтай байсан. Жас нь бас тийм байсан юм. Тэгээд 1928 онд (38) шажин устаад бүгдийг нь шатаасан. Тийм л хурал байсан. Уугийн хурал гэж би өөрөө хурж байсан хурал. Намайг арван тавтай байхад шажин утсан юм байгаа юм.

-Уугийн хурал хэдэн дугантай байсан гэнэ ээ?

Хоёр дугантай байсан юм. Хурал хурдаг 2 дугантай. Нэг гэр дугантай. Жас нь бас гэр байсан юм. Гэр гэж томоо модон ханатай гэр шиг юм байсан юм. Хойд талын хурал гэж Лүндэгийн Нувааны хурал. Лүндэгийн Нуваан гэж

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

айхтар буянтай хүн байсан. Тэр хурал нь дөрвөлжин дугантай хурал байсан. Суурь бол бий. Хойно хүүхдийн овоо гэж байгаа. Тэр чинь бидний тахиж байсан овоо.

-Хэр олон ламтай байсан бэ?

Олон олон. Сайхан лам нар байсан. Миний 4,5 сайхан лам багш нар бүгдээрээ баригдаад бүгдээрээ алуулсан юм байгаа юм.

-Яг хэн хэн гэдэг хүн байсан бэ? Цол нь?

Тэрийг сайн мэдэхгүй. Сайхан том лам нар байсан юм даг. Гавж гэвш нар л байсан.

-Энд онцлох ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Янз бүрийн хурал хурна. Гэхдээ Лүндэгийн Нуваан гэдэг тэнд хурал байгуулаад Ганжуурын лүн тавиулсан. Ганжуурын лүнд би хүртэл сууж байсан.

-Хэн гэдэг хүн тавьсан юм болоо?

Бид Лүнгийн багш л гэдэг. Хаанаас билээ нэг сайхан лам нар ирж тавьсан.

-Төвд лам байсан үү? монгол хүн байсан үү?

Монгол хүн. Тэр Лүндэгийн Нуваан чинь өөрөө авчирч тавиулсан юм. Өөрөө яахав баригдаад сүүлд хаашаа гэлээ манай аймгийн тэнд хүүр нь байж байсан гэж байгаа. Тийм хурал байсан юм. Уугийн хурал гэдэг нь.

Энэ наана Хайлантын хурал гэж байсан. Дэлгэрхааны хурал. Үзүүр цохио гэдэг газарт бий.

-Бид нар Ренчин гуайн судалгаан дээр тулгуурлаж яваа л даа. энд Зараа булангийн хийд гэж тэмдэглэсэн байна. Зараа булан гэдэг чинь энд байсан гэдэг. Би мэдэхгүй. Хойно бас энэ Уугийн хурлын цаана Шивэрийн хурал гэж байсан юм. Тойно отгийн хурал гэж байсан юм. Бас л тусдаа хурал байхгүй юу. Уул отог, Тойн отог гэж байсан.

- Хайлантын хурлын талаар?

Их хайлантын хурал гэж байсан. Үзүүр цохио гэдэг газар байдаг. Одоо ердөө амаа өгсөөд орохдоор байдаг юм. Гавъяа-Очир хойно нь байсан юм. Тэрний урдхан хурал байсан юм. Гавъяа-Очир гэдэг чинь том хүн байсан юм. Дээр үед орой дээрээ улаан үстэй их гээгтэй тийм лам байсан юм. Сүүлдээ хөгшрөөд оройны нь үс дун цагаан болоод тийм орой цагаан хүн байж байгаад манай энд нас барсан юм.

-Тэр хүн Хайлантын хуралд хурдаг байсан хүн үү?

Тийм. Хайлантын хуралд хурдаг байсан өөрөө их том лам. Говийн сангашир гэж байсан хүн. Говийн л хүн байсан юм байна лээ. Манай багш гэж шүтээн Гомбожав гэж байсан. Тэднийд очоод ирэхээр хонууд өнжүүд явна. Би тэгээд багшаасаа асууна. Энэ одоо ямар учир байна? гэж. Хай, айхтар хүн ш тээ. Говийн сангас гэдэг юм.

Мөрөө үлдээсэн үстэй толгойны орой дээрээ улаан үстэй байсан. Сүүлдээ үс нь бууралтаад буурал болсон.

Орой нь цагаан байсан. Манай энд хүнтэй сууж байсан ш дээ.

-Цагаан эргийн хурал гэж байсан байна. Та мэдэх үү?

Баян хааны уулын энд.

-Мааньтын хурал гэж?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жижиг жижиг хурлууд их байсан юм. 1938 онд энэ хавийн хурал устсан юм. Уугийн хурал тэр хавийг устсаныг сайн мэднэ. Цагаан сараар бурхан тахилаа хийчихээд бүхэл хонины мах энэ тэр тавьдаг байхгүй юу. Тэгсэн чинь ламыг нь барьж аваад явсан. Сүүлд би арван тавтай байсан. Цоодол Лувсандорж гэж байсан. Хоёр амсар дээр хоёр хүүхдийн мана гэж мануулаад. Олон хоносоон. Тэгээд манаж байсан чинь нэг өдөр хойноо жаахан гүүзүүтэй тэрэг ирсэн. Тэрэн дээр бүх юмыг нь ачаад урд овоолоод байсан. Тэгээд бид хоёр арван хэдтэй хүүхдүүд бензин энэ тэрийг мэдэхгүй. Тэгтэл усаар шүршээд л гал авалцуулсан. Шөнө туж асаад маргааш нь ассан. Замгүй их түймэр шиг гал гарсан. Бид харин тахилын мах, боов энэ тэрээс нь аваачаад, боов нь хөгцөрчихсөн байгаа юмаа. Тэгээд идэж уугаад байж байсан. Тэгсэн сүүлд хүмүүс тэрийг чинь ухаад мөнгөн эдлэлүүдийн авсан байсан. Тэр чинь одоо Намсрай бурхан гэж шүтээн нь байсан. Дэлгэмэл бурхан байсан. Түүний 2 талын дог нь 2-н бидон шиг тийм том байсан. Бүр нүд ам нь дандаа сувдаар хийгдсэн. Түүнээс аваачиж байгаад л шатаагаад байдаг. Бүгдийг нь шатаасан. Сүмийг шатаахыг мэдэх хүн, одоо амьд байгаа нь би байна. Лувсандорж маань үхсэн.

-Яг 1938 онд л юм байна тийм үү?

1938 оны цагаан сарын шинийн 2,3 нд л манаа тавьсан. Манаач нь өөр хүн байсан чинь элэг бариад хоёр жаахан хүүхэд тавьчихсан. Тэгээд нэг өдөр ирэхэд бүх л юмыг шатаагаад. Харин замгүй их мөнгө гарсан байхаа. Амьтан мөнгийг нь түүгээд л байдаг байсан.

-Лам нар нь хийдийнхээ хаагуур байрладаг байсан бэ?

Лам нар тэндээ. Миний 2,3 багш урд нь. Жигмэд гэлэн гэж байсан миний багш. Лүндэгийн Наваан ч миний багш. Бор Нуваан гэж байсан. Сүх гавж гэж байсан. Шүтээн Гомбожав гэж байсан. Шүтээн Гомбожав харин шажин устахын урд жил ойчоод өгсөн хүн. Олон сайхан багш нар байсан. Тэд нар бүгдээрээ л явсан. Нүржин Санжид гэдэг номыг асуугаад мэднэ гэвэл тэр намын эсрэг ном байсан юм байлгүй тэгээд под хийлгэдэг байсан юм гэсэн. Хэнтий аймгийн хойд энгэр, Өндөр хааны энгэр гэдэг чинь улаан шаргалтсан л юм байсан байгаа. Гэрээр дүүргэж аваачиж байгаад шөнө буудчихдаг байсан. Лүндэгийн Нуваан гэдэг чинь харин хөгшиндүү ч баригдсан хүн юм гэсэн яасныг мэдэхгүй үхсэн байсныг нь Жидгай Шарав гэж миний эгчтэй суусан нэг сайхан өвгөн байсан. Тэр аймаг дээр жин тээгээд явж байгаад үзсэн тэгээд өөрөө харин аваачаад бүр хөдөө тавьсан гэж байгаа юм. Жидгай Шарав гэж сайхан хүн байсан. Төрийн хар хүн байсан юм. Баруун хурлуудыг бол сайн мэдэхгүй. Манайх чинь зүүн талаар байсан юм.

-Шиврийн хурлаас бас таны санаанд байгаа юм байвал бидэнд ярьж өгөхгүй юу?

Сайхан хурал байсан. Тооно отгийн хурал гэж байсан. Цэнхэр мандалын наана. Тэнд Баянзүрх гэж уул байгаа. Зүүнтэй одоо Мэргэн хамбын хурал гэж байсан юм гэнэ лээ.

-Уугийн хурал хэдэн онд байгуулагдсан юм бол?

Тэр одоо намайг төрөөгүй байхад л бий болсон юм болов уу. Харин тэр Лүндэгийн Нувааны хурал шажин устахаас өмнө 2 байна үү 3 жилийн өмнө бий болсон. Их баян ч хүн байсан шооч ч хүн байсан. Тас тас хөхрөөд л байдаг байсан. Миний багш тийм хүн байлаа гээд л тас тас хөхөрч байдаг байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Ямар хүн байгуулсан юм бол? Баян хүн байгуулсан юм болов уу лам нар нь байгуулсан юм болов уу?

Лүндэгийн Нуваан өөрөө тэнд хурал байгуулаад тэнд чинь лам нар их олон байсан юм. Тэгээд нэг хэсэг лам нар аваачаад хуруулахгүй юу даа. Тэр Уугын хурлын энүүхэнд дуганын дөрвөлжин суурь байгаа. Тэр бол Лүндэгийн Нувааны байгуулсан хурлын дуганын суурь. Тэр дугуй гэр дугануудыг нь намайг төрөөгүй байхад байгуулсан юм. Гэр дугануудыг банзаар бариад завсараар нь аваачаад пүрүс шаачихсан байсан. Гэсгүй Жамба, Янхир Содном, Арзаа Жамаа тэд бүгдийг нураасан юм байгаа юм.

-Хайлантын хурлын талаар?

Би энэ талаар сайн мэдэхгүй. Нутаглаж байгаагүй болохоор. Гэхдээ хойноо дугантай л байсан байгаа юм. Хойноо дуганы бурханаа хийдэг хүзүүвч гэж байгаа. Очиход байж л байдаг юм.. Хайлантын хурлын түүхийг нь бол би мэдэхгүй.

-Уугийн хурлын тэр байсан бурхан тахилаас нь үлдсэн юм байдаг болов уу?

Байхгүй ээ. Би өөрийн нүдээр шатаахыг нь харсан. Машин тэрэгт аваачаад замгүй их овоолоод тэгээд усаар шүршлээ гэсэн бензин цацсан байсан. Тэгээд том том шатаасан ном нь тарваганы нүхний амаар номын үсэг тэр чигтээ байж байсан.

-Уугийн хуралд Алтан Ганжууртай байсан уу?

Байсан. Лүндэгийн Нуваан чинь хойно байгуулсан гэхэд замгүй их баян хүн байсан юм. Хэдэн хүүхдүүд нь үхээд 5 хүүтэй байсан 5-уулаа үхсэн.

-Та уугийн хуралд хэдэн настайдаа шавилан сууж байсан бэ? Та хэдэн онд төрсөн бэ?

Би 1923 онд төрсөн. 7,8-тайдаа суусан юм болов уу даа. Хэнгэрэг л цохидог хүн байлаа.15 хүртлээ суусан.

-Та хийдийнхээ цорж, гэсгүй, мяндагтнуудын нэрийг санаж байна уу?

Том л лам нар байсан гэдгээс өөр юм мэдэхгүй. Хамба ламыг нь ч мэдэхгүй. 1938 онд би 15-тай байсан. Одоогийнхоор дээд зиндааны хүн болох хүн байжээ дээ. Хурлынхаа бүх л доод номыг үзээд зиндаа нэмэх хүн байсан чинь шашин устчихсан. Тэгээд л өнгөрсөн хүн.

-Чойр, зурхай энэ тэрийг бүгдийг нь заадаг байсан уу?

Тэгэлгүй яахав. Тэнд бүгдийг заана.

-Тэнд гэвш гавжийн дамжаа барьдаг байсан уу?

Дандаа гавж нар гэвш нар гэдэг дандаа хотод очиж болдог байсан. Жигмэд гэдэг хүн хотод очиж гавж болж би хоол ундных нь хонийг маллахчаа тэнд Баянзүрхэд байж байлаа. Хөдөө нэг их барихгүй, дандаа хотод гавж барьдаг байлаа. Жигмэд гэдэг чинь Ханд гэдэг хүний ганц хүү нь байсан. Баригдаад. Тэгээд 7 жил билүү 8 жил яваад ирсэн. Тэгээд ирээд Баянмөнхөд очиж үхсэн. Баянмөнхөд дүү нь байсан. Дүү дээрээ очиж үхсэн. Сайхан хүн байсан. Ижийнх нь төрсөн дүү Сүх гээд хүн байсан. Дандаа миний багш нар байсан.

-Лам нар зохиол бичиж байсан уу? Уул овооны тахилгын судар?

Бичиж л байсан байх.

-Жас нь хаана байсан юм бол?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жас нь хажууд нь дуган шиг том дугуй модон. Тэгээд хоол унд хийнэ гээд нэг их том тогоонд хоол хийдэг байсан.

-Майдар эргэж маанийн бүтээл хийдэг байсан уу?

Үгүй. Майдар эргэхгүй. Хангал хайлан хамаг юм л хурдаг байсан. Нэг их олон лам байдаг байсан. Тэгээд баригдах хүн, баригдахгүй хүн байдаг юм байна лээ. Өвгөн улаан халзан гэж нэг том лам байсан. Тэр харин баригдаагүй. Ганцаараа нэг жижигхэн гэртэй. Хэзээ хойно нас барсан. Том лам байж баригдаагүй л юм даа. Өөрийгөө аргалаад байдаг байсан юм байлгүй. Уугийн хурлын тэр олон лам нар баригдахад өвгөн Лувсанцэрэн л баригдаагүй. Амьтан ярьдаг байсан. тэрнээс өөр Гэлэгийн Лувсанцэрэн гэдэг юу ч мэддэггүй байсан. Одоо энэ Байцын тэнд байдаг байсан. Тэр андуурагдаад баригдаад явсан.

-Багцаагаар уугийн хуралд хэдэн лам байсан юм бол?

Ойролцоогоор 100 гаруй лам байсан. Сайхан лам нар байсан юм. Залуухан лам нар үхээд дууссан. Занаа гэдэг хүн байсан. Саяхан нас барсан. Энэ тухай мэдэх хүн ч ховордож байсан. Занаагийн эцгийг лам байсан. Бид нар Буйлаа гэдэг байсан. Одоо Баатарын хошууны хурал гэж байсан гэдэг. Дандаа сайн лам нар байсан гэдэг. Олон ламтай байсан.

-Өөр танд энэ нутгийн хийдүүдийн талаар мэдэх юм байвал хэлж өгөөч?

Байхгүй байхгүй.